



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 167

Улаанбаатар  
хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

1. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор баталгаатай, чанартай, бэлэн байдлыг хангасан байрлалд сууринсан орон зайн өгөгдөл, мэдээлэл бүхий Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах ажлыг эрчимжүүлэх, орон зайн өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэгч, оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч

-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Гишүүд:

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Үндэсний хөгжлийн газрын дарга;

-Харилцаа, холбооны зохицуулах хорооны дарга;

-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга;

Ганчуудын  
Бандуусын тоо

- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга;
- Татварын ерөнхий газрын дарга;
- Ашигт малтмал, газрын тосны газрын дарга;
- Нийслэлийн Засаг дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
Мэдээллийн технологийн хэлтсийн дарга.

Нарийн бичгийн дарга Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга.

2. Ажлын хэсгийн удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.



## Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

ҮНДЭСНИЙ ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙГ БАЙГУУЛАХ АЖЛЫГ  
ЭРЧИМЖҮҮЛЭХ, ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, МЭДЭЭЛЭЛ БҮРДҮҮЛЭГЧ,  
ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ НЭГДСЭН  
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР ХАНГАХ ЧИГ ҮҮРЭГ  
БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Ажлын хэсгийн зорилго нь “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, хянах, үнэлэхэд шаардлагатай байрлалд сууринсан шинэлэг, баталгаатай, чанартай, бэлэн байдлыг хангасан орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж, Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах ажлыг эрчимжүүлэх, орон зайн өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэгч, оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангахад оршино.

1.2. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлт, боловсруулалт, хадгалалт, түгээлт болон орон зайн өгөгдөл, мэдээллийн хэрэглээг хамааруулан ойлгоно.

Хоёр. Чиг үүрэг

2.1. Ажлын хэсэг дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ:

2.1.1. Үндэсний хэмжээнд орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;

2.1.2. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар төрөөс баримтлах бодлогын зарчим, алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлох, төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгах холбогдох саналыг боловсруулах;

2.1.3. Монгол Улсад орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санал боловсруулах;

2.1.4. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, суурь тогтолцоог бий болгох чиглэлээр санал боловсруулах;

2.1.5. Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах суурь орон зайн мэдээллийн ангилал, эрэмбийг тогтоох, бэлэн байдлыг хангах чиглэлээр санал, шийдэл боловсруулах.

2.2. Ажлын хэсэг чиг үүргийн хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.2.1. Төрийн байгууллага, хэрэглэгчдээс ирүүлсэн санал, санаачилгыг хүлээн авч хэлэлцэх, шаардлагатай бол уг асуудлаар санал, зөвлөмж гаргах;

2.2.2. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн чиглэлээр хурал, зөвлөгөөн зохион байгуулах, орон зайн мэдээллийн ач холбогдол, хэрэглээг олон нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулах, сургалт, сурталчилгаа хийх;

2.2.3. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэмжих, хянах, үнэлэх явцыг дэмжих орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлт, систем, үйлчилгээ, өгөгдлийг цахим хэлбэрээр түгээх, хуваалцах, солилцох менежментийг хөгжүүлэх, тогтвorumжуулах асуудлаар судалгаа хийх, санал, зөвлөмж боловсруулах;

2.2.4. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих.

#### Гурав. Ажлын хэсгийн зохион байгуулалт

3.1. Ажлын хэсэг чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллана.

3.2. Ажлын хэсэг улиралд 1 удаа хуралдана.

3.3. Шаардлагатай тохиолдолд Ажлын хэсэг тодорхой нэг асуудлыг хэлэлцэх зорилгоор ээлжит бус хурал зохион байгуулж болно.

3.4. Ажлын хэсгийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга боловсруулан Ажлын хэсгийн ахлагчид танилцуулна.

3.5. Ажлын хэсгийн хурлын товоос ажлын 2 өдрийн өмнө Ажлын хэсгийн гишүүдэд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг албан ёсны цахим шуудангийн хаягаар хүргүүлнэ.

3.6. Ажлын хэсгийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудал, материалтай урьдчилан танилцаж, ээлжит хуралд санал бэлтгэж ирнэ.

3.7. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, хэлэлцсэн асуудлаар гарсан шийдвэр, түүнтэй холбоотой санал, судалгааны материалыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нэгтгэж албажуулна.

3.8. Ажлын хэсэг нь чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, дүрэм, журам, стандартын төсөл боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг байгуулж, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж болно.

3.9. Дэд ажлын хэсэг нь ажлын явц, үр дүнг Ажлын хэсгийн ахлагчид тухай бүр танилцуулж, тайлагнана.